

БАНКИЙГ ТОГТВОРЖУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, БАТЛУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг. Журмын ерөнхий зохицуулалт

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Банкны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д заасан банкныг тогтворжуулах төлөвлөгөөний бүтэц, агуулга, баталгаажуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2 Банкныг тогтворжуулах төлөвлөгөөний журам нь Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцтэй байна.
- 1.3 Банкныг тогтворжуулах төлөвлөгөөнд Засгийн газар, төсвөөс аливаа хэлбэрээр дэмжлэг, хөнгөлөлт авах арга хэмжээг тусгахгүй.
- 1.4 Банк нь Монголбанкнаас зээл авах арга хэмжээг тогтворжуулах төлөвлөгөөнд тусгаж болох ба энэ тохиолдолд банкны санхүүгийн нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөж, хүндрэхэд зээл авах хүсэлт гаргахыг тодорхой тусгана.
- 1.5 Тогтворжуулах төлөвлөгөө нь банк, банкны нэгдлийн оролцогчдын үйл ажиллагааг хамарсан байна.
- 1.6 Банк тогтворжуулах төлөвлөгөөний санхүүгийн үзүүлэлт бүрт энэ журмын Хавсралт 2-ын дагуу эрсдэлийн түвшинг эрсдэлийн удирдлагын бодлогод нийцүүлэн дотооддоо боловсруулж, батална.
- 1.7 Банк энэ журмын Хавсралт 2-т тодорхойлсон эрсдэлийн түвшин бүрт хариу авах тогтворжуулах арга хэмжээг төлөвлөгөөнд тусгана.
- 1.8 Банк энэ журмын 1.7-т заасан тогтворжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн тухай бүр Монголбанканд мэдэгдэнэ.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

- 2.1 “Тогтворжуулах төлөвлөгөө” гэж Банкны тухай хуулийн 47.1-т заасан төлөвлөгөөг;
- 2.2 “Банкны нэгдэл” гэж Банкны тухай хуулийн 3.1.6-д заасныг;
- 2.3 “Банкны нэгдлийн оролцогч” гэж Банкны тухай хуулийн 3.1.7-д заасныг;

- 2.4 “Системд ач холбогдол бүхий үйл ажиллагаа” гэж тухайн үйл ажиллагаа доголдоход эдийн засгийн бодит сектор болон санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөхүйц, бусад этгээд гүйцэтгэхэд хөрөнгө, хугацаа их шаардагдах үйл ажиллагааг;
- 2.5 “Банканд ач холбогдол бүхий үйл ажиллагаа” гэж зах зээлд танигдсан, тухайн банкны голлох ашиг, орлогыг бүрдүүлдэг, эсвэл тэдгээрийг дэмжих зорилготой туслах үйл ажиллагааг;
- 2.6 “Тогтворжуулах төлөвлөгөөний арга хэмжээ” гэж банканд учирч болзошгүй эрсдэлийг даван туулах хариу арга хэмжээг;
- 2.7 “Нөлөөллийн үнэлгээ” гэж банкны тогтворжуулах арга хэмжээ нь банкны санхүүгийн болон бизнесийн үйл ажиллагаа, банкны нэгдэл, гуравдагч тал, системд хэрхэн нөлөө үзүүлэх талаарх дүн шинжилгээг;
- 2.8 “Эрсдэлийн үнэлгээ” гэж банкны тогтворжуулах арга хэмжээнүүд нь бодитой хэрэгжих эсэх; хэрэгжүүлснээр үүсч болзошгүй сөрөг үр дагаврын дүн шинжилгээг;
- 2.9 “Хүндрэлт нөхцөлийн төсөөлөл” гэж системийн болон тухайн банкны санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлын таамаглалыг;

Гурав. Тогтворжуулах төлөвлөгөөний шаардлага

- 3.1 Банк, банкны нэгдлийн хууль эрхзүйн, санхүүгийн, үйл ажиллагааны талаарх төлөвлөгөөнд тусгах мэдээлэл нь үнэн зөв, иж бүрэн, цэгцтэй, тодорхой байна.
- 3.2 Тогтворжуулах төлөвлөгөө нь банкны стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө, чанаргүй активыг бууруулах стратеги төлөвлөгөө, зохистой засаглал, үйл ажиллагааны тасралтгүй байдлын төлөвлөгөө, банкны дотооддоо өөрийн хөрөнгө болон төлбөрийн чадварын хүрэлцээг үнэлэх үйл явц, эрсдэлийн удирдлага болон эрсдэл хүлээн зөвшөөрөх хэм хэмжээтэй уялдсан байна.
- 3.3 Тогтворжуулах төлөвлөгөө нь банкны дотоод аудитын байнгын шалгагдах бодлогын баримт бичиг байна.
- 3.4 Тогтворжуулах төлөвлөгөөг банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн эрсдэлийн хороо хянаж, Төлөөлөн удирдах зөвлөл баталгаажуулна.

Дөрөв. Тогтворжуулах төлөвлөгөөний бүтэц

- 4.1 Тогтворжуулах төлөвлөгөөний хураангуй;
- 4.2 Тогтворжуулах төлөвлөгөөний удирдлага, зохион байгуулалт;

4.3 Банкнйг тогтворжуулах арга хэмжээ боловсруулах, үнэлэх;

4.3.1 Банк, банкны нэгдлийн мэдээлэл;

4.3.2 Хүндрэлт нөхцөлийн төсөөлөл;

4.3.3 Тогтворжуулах арга хэмжээ;

4.3.3.1 Нөлөөллийн үнэлгээ;

4.3.3.2 Эрсдэлийн үнэлгээ;

4.4 Олон нийттэй харилцах стратеги;

4.5 Банкны урьдчилсан бэлтгэл арга хэмжээ;

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТОГТВОРЖУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АГУУЛГА

Тав. Тогтворжуулах төлөвлөгөөний хураангуй

5.1 Тогтворжуулах төлөвлөгөөний хураангуй хэсэгт дараах мэдээллийг тусгана.

5.1.1 Банканд үүсч болзошгүй хүндрэл, түүнийг тогтворжуулах гол арга хэмжээ, тэдгээрийн банкны санхүүгийн үзүүлэлтэд нөлөөлөх хэмжээ, удирдлагын шийдвэр гаргалтын үйл явц, олон нийт болон банк доторх мэдээллийн харилцаа холбооны зарчим зохион байгуулалт, урьдчилсан бэлтгэл арга хэмжээний талаар хураангуй мэдээлэл;

5.1.2 Тогтворжуулах төлөвлөгөөний өмнөх хувилбараас шинэчлэгдсэн материаллаг өөрчлөлтийн талаарх хураангуй мэдээлэл;

Зургаа. Тогтворжуулах төлөвлөгөөний удирдлага, зохион байгуулалт

6.1 Банк нь тогтворжуулах төлөвлөгөөг боловсруулсан газар нэгж, албан тушаалтны дараах мэдээллийг төлөвлөгөөнд тусгана.

6.1.1 Төлөвлөгөөний хэсэг бүрийг боловсруулсан, хэрэгжүүлэх, шинэчлэх газар нэгж, ажилтны мэдээлэл;

6.1.2 Төлөвлөгөөг нэгтгэх, хариуцах, холбоо барих ажилтны мэдээлэл;

6.2 Банк нь энэ журмын Хавсралт 2-т заасан санхүүгийн үзүүлэлтийн эрсдэлийн түвшинг тодорхойлж, эрсдэлийн түвшинд хүрэх, тогтворжуулах арга хэмжээ авах нөхцөл үүссэн тохиолдолд шийдвэр гаргалтын үйл явцын талаар дараах мэдээллийг төлөвлөгөөнд тусгана.

6.2.1 Тогтворжуулах арга хэмжээний үед гүйцэтгэх ажлын дараалал;

6.2.2 Тогтворжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх газар, нэгжийн чиг үүрэг, ажил үүргийн талаарх мэдээлэл;

6.2.3 Тогтворжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэр гаргах хугацаа;

6.3 Тогтворжуулах төлөвлөгөө нь удирдлагын мэдээллийн системтэй хэрхэн уялдсан талаарх дэлгэрэнгүй мэдээллийг төлөвлөгөөнд тусгана.

Долоо. Банкны тогтворжуулах арга хэмжээ боловсруулах, үнэлэх

7.1 Энэ хэсэгт төлөвлөгөөнд ашиглагдах суурь мэдээллүүд, банкны хувьд системд ач холбогдол бүхий болон банканд ач холбогдол бүхий үйл ажиллагааг (*Хавсралт 3-т оруулсан мэдээллийг харгалзан үзнэ.*) тодорхойлж, тэдгээрийг санхүүгийн хүндрэлт нөхцөлийн төсөөллийн үед хэрхэн авч үлдэх, үргэлжлүүлэх цогц арга хэмжээг тусгана.

7.2 Банк, банкны нэгдлийн мэдээлэл:

7.2.1 Банкны нэгдлийн бүтэц, зохион байгуулалт, түүний оролцогчийн харилцан хамаарал, эзэмшлийн хувь хэмжээ, оролцогч тус бүрийн эцсийн өмчлөгчийн мэдээлэл;

7.2.2 Банкны бүтэц, зохион байгуулалт, газар, нэгж тус бүрийн чиг үүрэг;

7.2.3 Банкны үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэх газар нэгжийн оролцооны мэдээлэл (*Хавсралт 5-ын дагуу*), схем зураглал;

7.2.4 Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ тус бүрийн санхүүгийн үзүүлэлтийн мэдээлэл (*Хавсралт 6-ын дагуу*);

7.2.5 Энэ журмын 7.2.3, 7.2.4-т заасан үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээг системд ач холбогдол бүхий, банканд ач холбогдол бүхий болон бусад гэсэн дарааллаар эрэмбэлэн тусгана.

7.2.6 Системд ач холбогдол бүхий үйл ажиллагаа, банканд ач холбогдол бүхий үйл ажиллагааг энэ журмын 2.4, 2.5-т заасны дагуу тодорхойлж, жагсаалт үйлдэн тайлбарын хамт хавсаргана.

7.3 Хүндрэлт нөхцөлийн төсөөлөл:

7.3.1 Банк нь системийн хэмжээнд болон тухайн банканд үүсч болзошгүй хүндрэлт нөхцөлийн төсөөллийг тодорхойлж, дараах нөхцөлийг хангасан 3-аас багагүй хувилбараар төлөвлөгөөнд тусгана.

7.3.1.1 Санхүүгийн системийн болон бодит эдийн засагт ноцтой сөрөг үр дагавар авчрах эрсдэлтэй үйл явдлыг илэрхийлсэн “системийн хэмжээний арга хэмжээ”;

7.3.1.2 Томоохон зээлдэгч, банкны нэгдэл, банк доторх ноцтой сөрөг үр дагавар авчрах эрсдэлтэй үйл явдлыг илэрхийлсэн “өвөрмөц шинжтэй үйл явдал”;

7.3.1.3 Энэ журмын 7.3.1.1, 7.3.1.2-т заасан хосолмол хэлбэрээр таамаглах үйл явдал;

7.3.2 Банк нь хүндрэлт нөхцөлийн төсөөллийг богино (12 сар хүртэл) болон урт (3 жил хүртэл) хугацаанд нөлөөлөхүйц байдлаар дараалуулан таамаглана.

7.4 Тогтворжуулах арга хэмжээ:

7.4.1 Банк нь энэ журмын 7.3-т заасан хүндрэлт нөхцөлийн төсөөлөл тус бүрт хэрэгжүүлэх санхүүгийн тогтвортой байдлыг хангах буюу системд болон банканд ач холбогдол бүхий үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, эрсдэлийг даван туулах, банкны төлбөрийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулах шаардлагыг хангасан тогтворжуулах арга хэмжээг тодорхойлно.

7.4.2 Энэ журмын 7.4.1-т заасан тогтворжуулах арга хэмжээ тус бүрт 7.4.3, 7.4.4-т заасан дараах үнэлгээг хийнэ.

7.4.3 Нөлөөллийн үнэлгээ:

7.4.3.1 Банкны дотоод нөхцөл байдлын: Үүнд төлбөрийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, өөрийн хөрөнгө, ашигт ажиллагаа, банкны болон банкны нэгдлийн үйл ажиллагаанд ямар нөлөө үзүүлж байгааг тоон болон чанарын үзүүлэлт, дэлгэрэнгүй тайлбар;

7.4.3.2 Банкны гадаад нөхцөл байдлын: Үүнд системд үзүүлэх нөлөөлөл, хувьцаа эзэмшигч, харилцагч, хамтран ажиллагч байгууллага, бэлтгэн нийлүүлэгчдэд ямар нөлөө үзүүлж байгааг тоон болон чанарын үзүүлэлт, дэлгэрэнгүй тайлбар;

7.4.3.3 Энэ журмын 7.4.3.1, 7.4.3.2-т дурдсан үнэлгээнд ашигласан таамаглалууд, үнэлгээний аргачлал, хэрхэн үнэлгээ хийсэн процессын дэлгэрэнгүй тайлбар;

7.4.4 Эрсдэлийн үнэлгээ:

7.4.4.1 Тогтворжуулах арга хэмжээ нь төлөвлөсөн цаг хугацаанд бодитой, үр дүнтэй хэрэгжих боломжит байдлын үнэлгээ;

7.4.4.2 Тогтворжуулах арга хэмжээг хэрэгжүүлснээр үүсч болзошгүй сөрөг үр дагаврын талаарх үнэлгээ;

7.4.4.3 Энэ журмын 7.4.4.1, 7.4.4.2-т дурдсан эрсдэлийг удирдах, шийдвэрлэх арга хэмжээ;

Найм. Олон нийттэй харилцах стратеги

8.1 Санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүднээс банк хүндрэлт нөхцөлийн төсөөлөл тус бүрт олон нийт болон банк доторх мэдээллийн харилцаа холбооны зарчим зохион байгуулалтыг тусгасан олон нийттэй харилцах стратегийг дараах 2 түвшинд боловсруулна.

8.1.1 Банк доторх мэдээллийг удирдах буюу нийт ажилтнууд руу чиглэсэн стратеги;

8.1.2 Олон нийтэд буюу хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, харилцагчид, хамтран ажилладаг байгууллагууд, бэлтгэн нийлүүлэгчид, эрх бүхий байгууллагууд руу чиглэсэн стратеги;

8.2 Олон нийттэй харилцах стратегид хэрэгжүүлэх ажил, хэрэгжилтийн шийдвэр гаргалтын үйл явц зэргийг хугацаа болон хариуцах албан тушаалтны хамт тодорхойлсон байна.

Ес. Банкны урьдчилсан бэлтгэл арга хэмжээ

9.1 Банк тогтворжуулах төлөвлөгөөг боловсруулах явцад түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд үүсч болзошгүй хүндрэлээс сэргийлэх, хугацаа хэмнэх болон цаашид сайжруулах шаардлагатай урьдчилсан бэлтгэл арга хэмжээг тодорхойлно.

9.2 Банкны урьдчилсан бэлтгэл арга хэмжээнд хэрэгжүүлэх ажил, хэрэгжилтийн шийдвэр гаргалтын үйл явц зэргийг хугацаа болон хариуцах албан тушаалтны хамт тодорхойлно.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ
ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА**

Ес. Тогтворжуулах төлөвлөгөөг тайлагнах

9.1 Банк нь тогтворжуулах төлөвлөгөөг энэхүү журамтай нийцүүлэн дараах хавсралтуудын хамт жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан Монголбанканд бичгээр болон цахим хэлбэрээр ирүүлнэ.

9.1.1 Тогтворжуулах арга хэмжээний нөлөөллийн үр дүнг Хавсралт 1-р;

9.1.2 Тогтворжуулах төлөвлөгөөний санхүүгийн гол үзүүлэлтүүдийн эрсдэлийн түвшинг Хавсралт 2-р;

9.1.3 Системд ач холбогдол бүхий болон банканд ач холбогдол бүхий үйл ажиллагааг тодорхойлох мэдээллийг Хавсралт 3-р;

9.1.4 Банкны салбар нэгжийн мэдээллийг Хавсралт 4-р;

9.1.5 Банкны үйл ажиллагаа тус бүрийн хэрэгжилтийн үе шат, түүнийг гүйцэтгэх газар нэгжийн оролцооны мэдээллийг Хавсралт 5-р;

9.1.6 Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ тус бүрийн санхүүгийн үзүүлэлтийн мэдээллийг Хавсралт 6-р;

9.2 Монголбанк тогтворжуулах төлөвлөгөөг шаардлага хангаагүй гэж үзвэл банк ажлын 5 хоногийн дотор дахин шинэчилж ирүүлнэ.

9.3 Банкны бүтэц зохион байгуулалтад тогтворжуулах төлөвлөгөөнд нөлөөлөхүйц хэмжээгээр өөрчлөлт орсон, санхүүгийн болон зохистой харьцааны үзүүлэлтүүд эрс муудсан эсвэл богино хугацаанд муудаж болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд банк тогтворжуулах төлөвлөгөөг нэн даруй шинэчлэн Монголбанканд хүргүүлнэ.

Арав. Тогтворжуулах төлөвлөгөөг хянах

10.1 Монголбанк нь Банкны тухай хуулийн 47.3 заалтад заасны дагуу банкнаас ирүүлсэн тогтворжуулах төлөвлөгөөг шаардлага хангасан эсэхэд хяналт тавьж ажиллана.

10.2 Монголбанк нь энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж, журмын заалтыг зөрчсөн этгээдэд Банкны тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

[illegible]

Банкны нэр:

Тайлагналын огноо:

"Банкийг тогтворжуулах төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх журам"-ын Хавсралт 2

№	Санхүүгийн үзүүлэлт /Эрсдэлийн хүчин зүйлс/	Урьдчилан сэргийлэх эрсдэлийн түвшин	Тогтворжуулах арга хэмжээ	Тогтворжуулах төлөвлөгөөний эрсдэлийн түвшин
1	2	3	4	5
1	Төлбөрийн чадварын харьцаа			
1.1	Түргэн борлогдох актив/Нийт актив			
1.2	Түргэн борлогдох актив/Богино хугацаат өр төлбөр			
1.3	ТТГЧ харьцаа			
2	Өөрийн хөрөнгийн хүрэлцээ			
2.1	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа			
2.2	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа			
3	Активын чанар			
3.1	Чанаргүй зээл/Нийт зээл			
3.2	Чанаргүй зээлийн өсөлтийн хувь			
3.3	Эрсдэлийн сан/Чанаргүй зээл			
4	Ашигт ажиллагаа			
4.1	Өөрийн хөрөнгийн өгөөж			
4.2	Активын өгөөж			
4.3	Цэвэр хүүгийн зөрүүний харьцаа			
4.4	Хүүгийн бус орлого, зардлын зөрүүний харьцаа			
5	Макро эдин засгийн үзүүлэлт			
5.1	Эрх бүхий байгууллагын үнэлгээний бууралт			
5.2	Хувьцааны үнийн хэлбэлзэл			
5.3	ДНБ-ын хэлбэлзэл			

[illegible]

"Банкийг тогтворжуулах төлөвлөгөө боловсруулах, батлуулах,
хэрэгжүүлэх журам"-ын Хавсралт 4

Банкны нэр:

Тайлагналын огноо:

Үзүүлэлт	Нэгдсэн баланс	салбар	салбар	салбар	салбар
Активын чанар					
Чанаргүй зээл/Нийт зээл					
Чанаргүй зээлийн өсөлтийн хувь					
Эрсдэлийн сан/Чанаргүй зээл					
Ашигт ажиллагаа					
ROA					
ROE					
Цэвэр хүүгийн зөрүүний харьцаа					
Хүүгийн орлого/Нийт орлого					
Хүүгийн зардал/Нийт орлого					
Хүүгийн бус зардал/Нийт орлого					
Хүний нөөцийн зардал/Хүүгийн бус зардал					
Цэвэр ашиг					
Үйл ажиллагааны үзүүлэлт					
Тухайн бүс нутагт эзлэх зах зээлийн хувь хэмжээ					
Нийт ажилтны тоо					
Харилцагчийн тоо					
Жилд хийгдэх гүйлгээний тоо					
АТМ, ПОС-ын тоо					

Банкны нэр:
Тайлагналын огноо:

"Банкийг тогтворжуулах төлөвлөгөө боловсруулах,
батлуулах, хэрэгжүүлэх журам"-ын Хавсралт 5

№	Үйл ажиллагаа			Хариуцан гүйцэтгэх газар, нэгж		Хамтран гүйцэтгэх газар, нэгж	
	Дэд төрөл	Д/д	Төрөл	Нэр	Үүрэг	Нэр	Үүрэг
1	Харилцах, хадгаламж	1.1	Иргэд				
		1.2	Засгийн газар				
		1.3	Улсын байгууллага				
		1.4	Хувийн байгууллага				
		1.5	Харьяат бусын харилцах, хадгаламж				
		1.6	Бусад [нэмж тусгах]				
2	Зээл	2.1	Хэрэглээний зээл				
		2.2	Цалингийн зээл				
		2.3	Кредит картын зээл				
		2.4	Авто машины зээл				
		2.5	Тэтгэвэрийн зээл				
		2.6	Хадгаламж барьцаалсан зээл				
		2.7	Малчны зээл				
		2.8	Орон сууцны зээл				
		2.9	Бизнесийн зээл				
		2.10	Корпорейт				
		2.11	Уул уурхай				
		2.12	Барилга				
		2.13	Бөөний болон жижиглэнгийн худалдаа				
		2.14	Боловсруулах				
		2.15	Үл хөдлөх хөрөнгө				
		2.16	ЖДҮ-ийн				
		2.17	Бөөний болон жижиглэнгийн худалдаа				
		2.18	Үйлдвэрлэл				
		2.19	Боловсруулах				
		2.20	Үйлдвэрлэл				
		2.21	Боловсруулах				
		2.22	Улсын байгууллага				
		2.23	Бусад [нэмж тусгах]				
3	Төлбөр тооцоо, клиринг, кастодиан		Бусад санхүүгийн байгууллагад төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлдэг эсэх				
		3.1	Санхүүгийн бус байгууллагад төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлдэг эсэх				
		3.2	Бэлэн мөнгөний үйлчилгээ				
		3.3	Үнэт цаасны төлбөр тооцооны үйлчилгээ				
		3.4	Клирингийн төв үйлчилгээ - CCP				
		3.5	Кастодианы үйлчилгээ				
		3.6	Бусад [нэмж тусгах]				
4	Хөрөнгийн зах зээл	4.1	Арилжааны зорилготой дериватив - биржийн гадуурх				
		4.2	Арилжааны зорилготой дериватив - биржээрх				
		4.3	Хоёрдогч зах /арилжаа (зөвхөн арилжааны зорилгоор)				
		4.4	Анхдагч зах / Андеррайтинг				
		4.5	Бусад[нэмж тусгах]				
5	Банк санхүүгийн байгууллагад байршуулсан байгууллагаас татсан эх үүсвэр	5.1	Банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр				
		5.2	Дотоодын банкууд				
		5.3	Дотоодын бусад санхүүгийн байгууллага				
		5.4	Гадаадын банк санхүүгийн байгууллага				
		5.5	Дериватив (хөрөнгө)				
		5.6	Банк санхүүгийн байгууллагад олгосон санхүүжилт				
		5.7	Дотоодын банкууд				
		5.8	Дотоодын бусад санхүүгийн байгууллага				
		5.9	Гадаадын банк санхүүгийн байгууллага				
		5.10	Дериватив (эх үүсвэр)				
		5.11	Бусад [нэмж тусгах]				

Банкийг тогтворжуулах төлөвлөгөө боловсруулах, багцуулах,
хэрэгжүүлэх журам-ын Хавсралт 6

Бүлэг 1: Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Бүлэг 2: Тоон мэдээллийг оруулах

1.1 Бүтээгдэхүүн, үйлчилгээний задаргаа/ төрөл			
№	Дэд төрөл	Д/д	Гөрөл
1	Харилцах, хадгаламж		
2	Зээл		
3	Төлбөр тооцоо, клиринг, кастодиан		
4	Хөрөнгийн зах зээл		
5	Банк санхүүгийн байгууллагад байршуулсан, байгууллагаас татсан эх үүсвэр		

[illegible]